



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх
журам батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.10, 22.11 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1.5 дахь заалт, 79 дүгээр зүйлийн 79.1, 79.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам”-ыг 1 дүгээр, “Тоймын загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны шүүхийн Тамгын газрын дарга нарт, хэрэгжилтэд нь хяналт тавихыг Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Р.Батрагчаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

202205716

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам (цаашид “журам” гэх)-аар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг олон нийтэд ойлгуулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор шүүгч, шүүх бүрэлдэхүүн гаргасан шүүхийн шийдвэрээ энгийн, ойлгомжтой хэлбэрээр тоймлон тайлбарлах, шуурхай мэдээлэх, түгээхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5, 22 дугаар зүйлийн 22.10, 22.11 дэх хэсэгт зааснаар шүүгч, шүүх бүрэлдэхүүн гаргасан шүүхийн шийдвэрээ биечлэн, ойлгомжтой байдлаар бичгээр тайлбарлахад энэ журмыг баримтална.

1.3.Энэ журмыг Монгол Улсын шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Хоёр.Нэр томьёоны тодорхойлолт

2.1.Энэ журамд заасан дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.тойм нь шүүхийн шийдвэрийн тойм болон шүүхийн процессын тойм гэсэн төрөлтэй байна;

2.1.2.“шүүхийн шийдвэрийн тойм” гэж шүүгч, шүүх бүрэлдэхүүн хянан шийдвэрлэсэн эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр (шийдвэр, захирамж, магадлал, тогтоол)-ийн хуулийн заалт, хууль зүйн нэр томьёо, үйл баримт, үндэслэл, шийдлийг энгийн, ойлгомжтой үг хэллэгээр, бичгээр товчлон тайлбарласныг;

2.1.3.“шүүхийн процессын тойм” гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа болон эцэслэн шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны нэг болон хэд хэдэн хэрэг, маргааны процесс ажиллагааны талаарх хуулийн заалт, хууль зүйн нэр томьёо, үйл баримт, үндэслэл, шийдлийг энгийн, ойлгомжтой үг хэллэгээр, бичгээр товчлон тайлбарласныг.

Гурав.Шийдвэр сонгох, тойм бэлтгэн гаргах хугацаа

3.1. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд тоймыг бэлтгэнэ:

3.1.1. шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд тоймыг тухай бүр бэлтгэнэ:

3.1.1.1. хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор мэдээлэл хүссэн бол;

3.1.1.2. хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээнд бодит байдлаас зөрүүтэй, төөрөгдүүлсэн зэрэг мэдээлэл гарч, үнэн зөв мэдээллээр хангах шаардлага үүссэн, шүүхэд итгэх олон нийтийн итгэлд сөрөг нөлөөлөхүйц нөхцөл байдал бий болсон, эсхүл энэ талаар тухайн шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид "Ерөнхий зөвлөл" гэх)-ийн хэвлэл мэдээлэл хариуцсан нэгжээс мэдэгдсэн бол;

3.1.1.3. тойм гаргасны дараа уг шийдвэр өөрчлөгдсөн, эсхүл хүчингүй болсон бол.

3.1.2. энэ журмын 3.1.1-д заасан тохиолдолд шүүгчдийн зөвлөгөөн сүүлийн гурван сарын хугацаанд гарсан, тухайн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг энэ журмын 1.1-д заасан зорилгоор олон нийтэд тайлбарлах ач холбогдолтой гэж үзвэл шүүгч, шүүх бүрэлдэхүүн, эсхүл Ерөнхий шүүгч ажлын гурван өдрийн дотор тойм бэлтгэж олон нийтэд мэдээлнэ. Энэ тоймыг нийслэл дэх шүүх сард хоёроос доошгүй, орон нутаг дахь шүүх сард нэгээс доошгүй удаа бэлтгэн гаргана.

3.2. Энэ журмын 3.1.1-д заасан тохиолдолд тойм бэлтгэн гаргахад дараах хугацаа, журмыг баримтална:

3.2.1. шүүхийн шийдвэрийг тоймлон мэдээлэх талаар энэ журмын 3.1.1-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүний аль нэг шүүгч уг өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор;

3.2.2. энэ журмын 3.1.1-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар шийдвэрийг өөрөө тоймлох боломжгүй тохиолдолд тухайн шүүхийн Ерөнхий шүүгч тоймыг ажлын гурван өдрийн дотор.

3.3. Энэ журмын 3.1.1.1, 3.1.1.2-т заасан тойм бэлтгэн гаргахад тухайн шүүхийн шийдвэр бичгээр албажсан, эсхүл хуулийн хүчин төгөлдөр болсон байхыг шаардахгүй.

3.4. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн энэ журмын 3.1.1 болон 3.1.2-т заасан тохиолдолд өөрийн шийдвэрлэсэн хэрэг, маргааны талаарх шийдвэрийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.10, 22.11 дэх хэсэгт заасны дагуу тоймлож, өөрийн нэрээр гаргана.

3.5. Тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын газар тоймын агуулга, найруулга, хэлбэрийг олон нийтэд ойлгомжтой байлгах талаар санал өгч болно.

3.6. Шүүхийн Тамгын газар энэ журмын 3.1.1.2-т заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдээллээр шүүгчдийг цаг тухайд хангана.

Дөрөв. Тоймын агуулга, хэлбэрт тавигдах шаардлага

4.1.Шүүхийн шийдвэрийн тоймын агуулгад хэрэг, маргааны товч танилцуулга буюу хэрэг, маргааны төрөл, зүйл, талууд, тогтоогдсон үйл баримт, холбогдох хуулийн зохицуулалтын ерөнхий утга, шүүхийн шийдвэрийн үндэслэл, шийдлийн тайлбарыг багтаана.

4.2.Шүүхийн процессын тоймын агуулгад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны товч танилцуулга буюу хүсэлт гомдол, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, хуулийн зохицуулалтын ерөнхий утга, захирамж тогтоолын үндэслэлийн тайлбар зэргийг багтаана.

4.3.Тоймд шүүхийн шийдвэрийн үндэслэлд дурдаагүй дүгнэлт, агуулга, хувийн сэтгэгдэл, зөвлөгөө болон хувь хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан нууц, эмзэг мэдээллийг тусгахгүй.

4.4.Хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад олон нийтэд нэгэнт ил болсон мэдээлэл бүхий шүүхийн шийдвэрийг энэ журмын 3.1.1.1, 3.1.1.2-т заасан нөхцөл байдлын улмаас тоймлох тохиолдолд энэ журмын 4.6, 4.7-д заасан шаардлага хамаарахгүй.

4.5.Тойм нь энэ журмын 4.1, 4.2-т заасан товч танилцуулгаас гадна доор дурдсан хэлбэрийн шаардлагыг хангасан бүтэцтэй байна:

4.5.1.тоймын агуулгыг илэрхийлсэн гарчиг;

4.5.2.шүүхийн шийдвэрийн огноо, дугаар;

4.5.3.тоймыг олон нийтэд мэдээлсэн огноо;

4.5.4.шүүхийн шийдвэрийн төлөв /хүчин төгөлдөр болсон эсэх/;

4.5.5.шүүхийн шийдвэрийн, эсхүл процессын тоймын аль нь болох, тухайн шүүхийн хэд дэх тойм болохыг тодорхойлсон дугаар;

4.5.6.“Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.” гэх санамж;

4.5.7.шийдвэрийг бүтнээр харах цахим холбоос;

4.5.8.тойм бэлтгэсэн шүүх, шүүгчийн нэр.

4.6.Тоймд хүний нууц, эмзэг мэдээллийг оруулахгүйгээр нас, хүйс, ажил эрхлэлтийн ерөнхий мэдээллээр төлөөлүүлнэ. Нэр бичих зайлшгүй тохиолдолд хүний нэрийн эхний үсгээс өөр, нэг үсгээр төлөөлүүлнэ. Жишээ нь, 32 настай, хувиараа худалдаа эрхлэгч; нэгэн төрийн албан хаагч; 18 настай нэгэн эрэгтэй оюутан; иргэн “А”-г “Б” гэх мэт.

4.7.Тоймд хуулийн этгээдийн нэрийг үйл ажиллагааны чиглэл, төрөл зэрэг ерөнхий мэдээллээр төлөөлүүлнэ. Нэр бичих зайлшгүй тохиолдолд хуулийн этгээдийн эхний үсгээс өөр, нэг үсгээр төлөөлүүлнэ. Жишээ нь, нэгэн банк; нэгэн банк бус санхүүгийн байгууллага; барилгын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг нэгэн компани; байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг нэгэн төрийн бус байгууллага; “АБВ” ХХК-ийг “Г” ХХК гэх мэт.

Тав.Тоймыг олон нийтэд түгээх, хадгалах

5.1.Шүүхийн Тамгын газар тоймыг шүүхийн цахим хуудаст байршуулах, хадгалах, олон нийтэд хүргэх, түгээх үүрэг хүлээнэ.

5.2.Шүүхийн Тамгын газар тоймыг шүүхийн цахим хуудаст байршуулахын өмнө уг тойм энэ журмын 4.5-д заасан хэлбэрийн шаардлагыг хангаж буй эсэх, зөв бичгийн дүрмийн болон бусад техникийн алдаатай эсэхийг нягталж, шаардлагыг хангуулна.

5.3.Тоймыг шүүхийн цахим хуудаст тусдаа цэс үүсгэж, ил харагдахуйц байршуулна.

5.4.Шүүхийн Тамгын газар тоймыг төрөл, огноо, дугаараар нь ангилж, өөрийн цахим хуудаст нэгтгэн хадгална.

5.5.Тойм гаргасны дараа шүүхийн шийдвэрийн төлөв өөрчлөгдсөн буюу хүчин төгөлдөр болсон, өөрчлөгдсөн, эсхүл хүчингүй болсон тохиолдолд энэ журмын 4.5.4-т заасан шүүхийн шийдвэрийн төлөвийг устгахгүйгээр дарж, ямар шийдвэрээр хүчин төгөлдөр болсон, өөрчлөгдсөн, хүчингүй болсон тухай мэдээллийг нэмж тусгана. Жишээ нь, шийдвэрийн төлөв: ~~Хүчин төгөлдөр болоогүй~~. Тодруулга: ...шүүхийн ... оны ... сарын ...-ны өдрийн ...дугаар шийдвэрээр хүчин төгөлдөр болсон.

5.6.Шүүхийн цахим хуудаст байршуулсан тоймыг Ерөнхий зөвлөл, бүх шатны шүүхийн Тамгын газар олон нийтэд түгээх ажлыг гүйцэтгэнэ.

5.7.Шүүхийн цахим хуудаст байршуулсан тойм нь тухайн шийдвэрийн талаарх албан ёсны эх сурвалж болно. Тоймыг дамжуулан түгээхдээ засварлахыг хориглох бөгөөд албан ёсны эх сурвалжийг заавал дурдана.

5.8.Тоймыг олон нийтэд түгээхдээ тоймын агуулга, хэлбэрийг аливаа байдлаар өөрчлөхийг хориглоно.


Зургаа.Бусад

6.1.Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн тухайн шүүхээс гаргах тоймыг бэлтгэх ажлыг зохион байгуулна.

6.2.Бүх шатны шүүхийн Тамгын газар тоймын хэлбэрийн шаардлагыг хангуулах, цахим хуудаст байршуулах, олон нийтэд түгээх ажлыг хариуцна.

6.3.Тоймыг бэлтгэх нөхцөл байдал, шаардлага үүссэн талаарх мэдээллээр шүүхийг хангахад Тамгын газарт арга зүйн туслалцаа үзүүлэх, олон нийтэд түгээх, нэгдсэн статистик мэдээг гаргах ажлыг Ерөнхий зөвлөлийн хэвлэл мэдээлэл хариуцсан нэгж гүйцэтгэж, улирал тутамд мэдээлнэ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн
2022 оны 343 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОЙМ

/загвар/

ГАРЧИГ

/Гол агуулгыг илэрхийлсэн 12-оос ихгүй үгтэй байх/

Шүүхийн нэр, шийдвэрийн дугаар: шүүх, он, сар, өдөр №1234

Тоймын дугаар, огноо: № ..., он, сар, өдөр

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болоогүй/Хүчин төгөлдөр болсон

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

Агуулга:

- хэрэг маргааны төрөл, зүйл, талууд
- тогтоогдсон үйл баримт
- хуулийн зохицуулалтын ерөнхий утга
- шүүхийн шийдвэрийн үндэслэл
- шийдлийн тайлбар

Шийдвэрийг бүтнээр харах цахим холбоос: <https://shuukh.mn...>

Тоймыг бэлтгэсэн: /шүүх, шүүгчийн албан тушаал, нэр/

ШҮҮХИЙН ПРОЦЕССЫН ТОЙМ

/загвар/

ГАРЧИГ

/Гол агуулгыг илэрхийлсэн 12-оос ихгүй үгтэй байх/

Шүүхийн нэр, шийдвэрийн дугаар: шүүх, он, сар, өдөр №1234

Тоймын дугаар, огноо: № ..., он, сар, өдөр

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болоогүй/Хүчин төгөлдөр болсон

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

Агуулга: -хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны товч танилцуулга буюу хүсэлт гомдол

-хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц

-хуулийн зохицуулалтын ерөнхий утга

-захирамж тогтоолын үндэслэлийн тайлбар

Шийдвэрийг бүтнээр харах цахим холбоос: <https://shuukh.mn...>

Тоймыг бэлтгэсэн: /шүүх, шүүгчийн албан тушаал, нэр/

ХУУЛЬ ЁСООР ҮҮСЭЭГҮЙ ЭРХИЙГ ШҮҮХ ХАМГААЛАХГҮЙ

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021.12.08-ны өдрийн №128/ШШ2021/0840 шийдвэр

Шүүхийн шийдвэрийн тойм № 11, 2022.11.15

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болсон.

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

Нийслэлийн Засаг даргын захирамжаар иргэн “Э”-д 3565 м.кв газрыг Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 2018 онд олгосон, ингэхдээ дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулаагүйн зэрэгцээ тухайн газар нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуй нэгжид эзэмшүүлэхээр төлөвлөгдөөгүй байжээ.

Нийслэлийн Засаг дарга иргэн “Э”-д газар эзэмшүүлсэн захирамжаа 2020 онд өөрөө хүчингүй болгосон, үндэслэлээ “... хууль зөрчиж газар эзэмшүүлсэн, уг газар нь Нисэх-Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөнд зааснаар авто зам тавихаар төлөвлөгдсөн байгаа. Мөн нийслэлийн төр, захиргааны байгууллагууд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт шилжин байрших болсонтой холбогдуулан гүүрэн гарц барих төлөвлөгөөнд давхар тусгагдсан” гэжээ.

Иргэн “Э” уг захирамжийг эс зөвшөөрч хүчингүй болгуулахаар шүүхэд маргасан, нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нийслэлийн Засаг дарга иргэн Энх-д анх газар олгохдоо Газрын тухай хуулийн хэд хэдэн заалтыг зөрчиж газар эзэмшүүлсэн байх тул уг хууль бус шийдвэрээ өөрөө хүчингүй болгосон нь Газрын тухай хуульд нийцсэн гэж дүгнэж, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

Иргэн “Э” нь энэ тохиолдолд газар эзэмших эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж аваагүй буюу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заагдаагүй байршилд газар олгогдсон, түүнчлэн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах журмаар газар эзэмших эрх үүсээгүй байх тул иргэн Энхийн газар эзэмших эрх нь хууль ёсны дагуу үүссэн гэж үзэхгүй, нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн гэж дүгнэх үндэслэлгүй гэж шүүх үзжээ.

Шийдвэрийг бүтнээр харах цахим холбоос: <https://admincourt.gov.mn/cat03/397-turshiltaar-huul-esoor-seegy-erhiyg-shh-hamgaalahgy.html>

Тоймыг бэлтгэсэн: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Цэцэг.

**БУСДЫН ГЭЭГДҮҮЛСЭН ЭД ХӨРӨНГИЙГ ОЛЖ АВЧ ЗАВШСАН ЭТГЭЭДЭД
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭВ**

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.11.11-ний өдрийн №490 шийдвэр

Шүүхийн шийдвэрийн тойм №6, 2022.12.05

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болсон.

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

Иргэн “Ц” найзуудтайгаа зоогийн газарт үйлчлүүлж байгаад тамхины өрөөнд иргэн “Д”-ийн мартаж орхисон Айфоне 12 про макс загварын гар утсыг олж аваад, хэн нэгэнд мэдэгдэлгүйгээр өөртөө үлдээж, утсыг бусдад худалдан борлуулсан байна.

Эрүүгийн хуульд зааснаар гээгдэл эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол эрүүгийн гэмт хэрэгт тооцохоор заасан, Сүхбаатар дүүргийн Прокурорын газраас иргэн Ц-г уг гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж гэм буруутай эсэхийг шийдвэрлүүлэхээр хэргийг шүүхэд ирүүлжээ.

Гээгдэл эд хөрөнгө гэж аливаа этгээдийн санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас мартаж орхисон, хаягдаж, гээгдсэн эд зүйлийг хэлэх бөгөөд түүнийг олсон этгээд энэ тухайгаа зохих байгууллагад мэдэгдэх үүргийг хуулиар хүлээлгэсэн бөгөөд шүүгдэгч Хангай нь энэ үүргээ биелүүлэхгүйгээр өөрийн олсон гар утсыг дур мэдэн захиран зарцуулж, ашиглан шамшигдуулсан гэм буруутай гэж шүүхээс дүгнэв.

Энэ гэмт хэргийг үйлдсэн хүнийг 450,000-2,700,000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр хуульд заасан, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал зэргийг харгалзан үзэж шүүхээс шүүгдэгч “Ц”-д торгох ял оногдуулж шийдвэрлэв.

Шүүхийн шийдвэрийг бүтнээр харах цахим холбоос:

https://shuukh.mn/single_case/66802?daterange=2022-01-01%20-%202022-10...

Тоймыг бэлтгэсэн: Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Цэцэг

АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ МЭДЭГДЭЛ ӨГСНИЙГ ХАРИЛЦАН ТОХИРОЛЦСОН ГЭЖ ҮЗЭХГҮЙ

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022.05.18-ны өдрийн №/ШШ2022/01560 шийдвэр

Шүүхийн шийдвэрийн тойм №16, 2022.11.25

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болсон.

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

“Б” ХХК-ийн захирал нь ажилтан Д-тэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачлагчаар цуцалж, ажлаас чөлөөлсөн тушаал гаргасан, Д уг тушаалыг эс зөвшөөрч шүүхэд хандан “ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны олговор гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийхийг даалгах” нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Хариуцагч “Б” ХХК-аас нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч, “хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж 20-оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 45 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөнө” гэж хуульд зааснаар ажилтан Д-д ажлаас чөлөөлөхийг мэдэгдэж, талууд харилцан тохирсон тул хууль зөрчөөгүй” гэж маргав.

Маргааныг шүүх хянан хэлэлцээд нэхэмжлэгч Д-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэлээ.

Хэрэгт авагдсан баримтаар, ажилтан Д нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаагүй бөгөөд “Б” ХХК-аас түүнийг ажлаас чөлөөлөх мэдэгдэл гардуулсан, талууд уг асуудлаар харилцан тохиролцсон гэдэг нь баримтаар нотлогдоогүй гэж шүүхээс үзсэн байна.

Харилцан тохиролцох гэдэг нь асуудлыг хамтран хэлэлцээд шийдлийг тохирох утгатай бөгөөд “Б” ХХК-аас ажилтан Д-д ажлаас чөлөөлөх мэдэгдэл өгснийг “ажлаас чөлөөлөх” асуудлаар харилцан тохиролцсон гэж үзэхгүй, энэ тохиолдолд, хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачлагчаар цуцалсан “Б” ХХК-ийн захирлын тушаал нь хууль зүйн үндэслэлгүй гэж шүүх дүгнэв.

Иймд, Д-г урьд эрхэлж байсан ажилд эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны олговор гаргуулж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийхийг ажил олгогчид үүрэг болгож шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэрийг бүтнээр харах цахим холбоос: [ЭНД](#) дарж үзнэ үү.

Тоймыг бэлтгэсэн: Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Цэцэг.

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ГАРАХЫГ ХЯЗГААРЛАВ

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.10.25-ны өдрийн шүүгчийн захирамж №801Шз

Шүүхийн процессын тойм №2, 2022.10.25

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болсон.

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

Прокуророос яллагдагч “М”-г ... өдөр тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ “Toyota Landcruiser 200” маркийн тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцохдоо Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн хэд хэдэн заалтыг зөрчсөний улмаас эсрэг урсгал сөрж, “Toyota Prius” маркийн 6, “Nissan Quashqai” маркийн 1, нийт 7 тээврийн хэрэгслийг мөргөж, явган хүний замаар явж байсан явган зорчигч 12 настай С, Э нарыг мөргөж, С-ын эрүүл мэндэд хөнгөн хохирол, нэр бүхий 7 иргэний нэхэмжлэгчид нийт 82.273.940 төгрөгийн буюу их хэмжээний хохирол учруулсан гэх хэрэгт яллагдагчаар татан, түүнд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах саналыг шүүхэд ирүүлжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагчийг мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулахгүй байлгах зорилгоор Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээг авах боломжтой байдаг. Прокурорын гаргасан санал үндэслэлтэй тул шүүгч хүлээн авч шийдвэрлэсэн.

Шүүхээс яллагдагч “М”-д эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Монгол Улсын хилээр гарахыг хориглох хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авав.

Шүүхийн шийдвэрийг бүтнээр нь үзэх цахим холбоос:
<https://shuukh.mn/...>

Тоймыг бэлтгэсэн: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Дорж.

**ИРГЭНИЙ АЖИЛЛАЖ БАЙСНЫГ ТОГТООХОД ШҮҮХ ӨӨРӨӨ НОТЛОХ БАРИМТ
ЦУГЛУУЛНА**

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022.05.13-ны өдрийн шүүгчийн захирамж №101/ШЗ2022/12094

Шүүхийн процессын тойм №1, 2022.12.12

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болсон.

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

Иргэн “С” нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох зорилгоор, 1987-1992 онуудад Улаанбаатар хотын нэгэн рестораны нарийн боовны цехэд шарагчаар ажиллаж байснаа тогтоолгох хүсэлтийг дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргажээ.

Иргэн “С”-г тухайн ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн тушаал болон бусад баримт архивд хадгалагдан үлдээгүй тул тэрээр өөрийн ажиллаж байсан байдлаа хамт ажиллаж байсан 2 хүнээр гэрчлүүлэхээс өөрөөр нотлох боломжгүй талаар шүүхэд тайлбарласан байна. Хуульд зааснаар, шүүх онцгой ажиллагааны журмаар зарим хэргийг шийдвэрлэдэг бөгөөд үүнд маргалдагч талгүй буюу хэн нэгэнтэй маргаагүй, харин эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг шүүхээр тогтоолгохоор гаргасан хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа хамаардаг.

Шүүх онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэхдээ хэргийн үйл баримт, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тогтоох зорилгоор өөрийн санаачилгаар тодорхой ажиллагаанууд явуулах боломжтой тул иргэн “С”-н хүсэлтийг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзэж, БНМАУ-ын Хүн амын регистрийн карт буюу ХААТР-1 маягт, Иргэний үнэмлэх авах өргөдөл ХААТР-21 маягтуудад түүний хөдөлмөр эрхлэлтийн байдал нь хэрхэн бичигдсэн байдлыг тодруулах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газраас нотлох баримт гаргуулахаар шийдвэрлэж, захирамж гаргав.

Шүүгчийн захирамжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн баримтаар иргэн “С”-н ажилд орсон хугацаа, ажиллаж байгаа байгууллагууд нь тодорхой болсон бөгөөд уг баримт нь гэрчийн мэдүүлэг, бусад баримтаар нотлогдсон тохиолдолд шүүхийн шийдвэрийн үндэслэл болох тул дээрх баримт нь хэрэгт ач холбогдолтой баримт болох юм.

Шүүх дээрх баримтуудад үндэслэн иргэн “С”-н ажиллаж байсан байдлыг тогтоосон шийдвэр гаргасан байна.

Шүүхийн шийдвэрийг бүтнээр нь үзэх цахим холбоос: <https://shuukh.mn/...>

Тоймыг бэлтгэсэн: Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч А.Дорж.

**ГАЗРЫН ХАРИЛЦААНД ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖТАЙ МАРГАХАД ДЭЭД
ШАТНЫ ЗАСАГ ДАРГАД ХАНДАХГҮЙ**

**Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022.12.09-ний
өдрийн шүүхийн тогтоол №221/ШТ2022/0993**

Шүүхийн процессын тойм №1, 2022.12.15

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр болсон.

Санамж: “Энэхүү тойм нь шүүхийн шийдвэрийг орлохгүй бөгөөд олон нийтийг мэдээллээр хангах зорилготой болно.”

Иргэн Ундрах газар эзэмших эрхийг нь хүчингүй болгосон дүүргийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрч нийслэлийн Засаг даргад гомдол гаргасан боловч нийслэлийн Засаг дарга түүний гомдлыг шийдвэрлээгүй байхад шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Анхан шатны шүүх “... гомдлыг нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх хуульд заасан хугацаа дуусаагүй байхад шүүхэд хандсан нь буруу” гэх агуулгаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ.

Ундрах уг шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасныг давж заалдах шатны шүүх хянаад, гомдлыг хангаж, шүүгчийн захирамжийг хүчингүй болгов.

Газрын маргааны хувьд Засаг даргын шийдвэрийг хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргахаар Газрын тухай хуульд тусгайлан заасан тул энэ хугацаанд Ундрах шууд шүүхэд хандах эрхтэй юм.

Өөрөөр хэлбэл, дүүргийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулахаар шууд шүүхэд хандах эрхтэй, заавал нийслэлийн Засаг даргад гомдол гаргасан байхыг шаардахгүй тул энэ үндэслэлээр шүүх Ундрахын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь буруу гэж давж заалдах шатны шүүхээс үзжээ.

Шүүхийн шийдвэрийг бүтнээр нь үзэх цахим холбоос: <https://shuukh.mn/...>

Тоймыг бэлтгэсэн: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч А.Дорж.